# ДАРХАН-УУЛ АЙМАГ "ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР" ХХК-ИЙН ГАНГИЙН ҮЙЛДВЭРИЙН 2025 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АЖ АХУЙ НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 2051303/

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:
"ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР" ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: _____________________ /Б.ЧАГНААДОРЖ/

"ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР" ХХК-ИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ АХЛАХ ИНЖЕНЕР _____________________/Л.ӨЛЗИЙХИШИГ/

**2025.10.30**

# АГУУЛГА

1. ТУХАЙН ЖИЛИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА....................4
2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....................5
3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....................11
4. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....................16
5. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ..........16
6. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ...............18
7. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ....................30
8. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....................32
9. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД, ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ....................37
10. ДҮГНЭЛТ....................40
11. ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД....................41

## ЗУРАГ

*Зураг 1 Гангийн үйлдвэрийн төлөвлөгөө гүйцэтгэл*
*Зураг 2 Асгаралтын иж бүрдэл*
*Зураг 3 Хог хаягдлын ангилан ялгалт хийж буй байдал*
*Зураг 4 Хаягдал тоосго ашиглан явган хүний зам хийсэн байдал*
*Зураг 5 Шинээр суурилуулсан 2 ш био ОО*
*Зураг 6 Бохир ус дамжуулах хоолойн холбоосуудаар ус алдалтыг шалгаж буй байдал*
*Зураг 7 Анхааруулах тэмдэг байршуулсан байдал*
*Зураг 8 Мод сөөгөнд тайралт таналт хийж хэлбэржүүлсэн байдал*
*Зураг 9 Зүлэг тарихаас өмнө*
*Зураг 10 Зүлэг тарьсны дараа*
*Зураг 11 Гал тогооны хажуу талын шинээр зүлэгжүүлсэн талбай*
*Зураг 12 Цэцгийн мандал хийсэн байдал*
*Зураг 13 Тасалгааны цэцэг шинээр худалдан авч байршуулсан байдал*
*Зураг 14 Төмөр хүний ард шинээр хашаалж мод тарьсан байдал*
*Зураг 15 Батлагдсан гамшгаас хамгаалах төлөвлөгөө*
*Зураг 16 Химийн бодисын аюултай хог хаягдал устгасан акт*
*Зураг 17 Эмнэлэгийн аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагад өгч устгуулж буй байдал*
*Зураг 18 Хаягдал тосыг мэргэжлийн байгууллагад нийлүүлж буй байдал*
*19 Үйлдвэрийн хэмжээнд хаягдал тос ачуулсан мэдээ*
*Зураг 20 Аюултай хог хаягдлын дагалдах бичиг*
*Зураг 21-26 Бүх нийтийн цэвэрлэгээ хийсэн байдал*
*Зураг 27 Хогийн сав байршуулсан байдал*
*Зураг 28 Шинжилгээ хийж буй байдал*
*Зураг 29 Байгаль орчны менежментийн тогтолцоо ISO 14001:2015 стандартыг нэвтрүүлж гэрчилгээ гардан авч буй байда*
*Зураг 30 Байгаль орчны нийцлийн аудитын тайлан*
*Зураг 31 Батлагдсан байгаль орчны журам*
*Зураг 32 Байгаль орчны журмын танилцуулга хийж буй байдал*
*Зураг 33 Бүх ажилтны ХАБ-ын сургалт*

# НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК нь 33 хэлтэс, алба, цехтэй ба нийт 1550 орчим ажилчинтай, орон нутгийн хамгийн том ажил олгогч компанид тооцогддог. Хэрэглэгчдийн эрх ашигт нийцсэн, аюулгүй байдлыг бүрэн хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэхийн тулд материал, түүхий эдийн хяналт, үндсэн үйлдвэрлэл, технологийн шат дамжлагын хяналт, худалдан борлуулах, хадгалах бүхий л үе шатанд чанарын удирдлагын хяналтын тогтолцоог бүрдүүлэн ажилладаг. Түүнчлэн олон улсын болон үндэсний ISO/IEC 17025:2005 (MNS ISO/IEC 17025:2007) стандартын шаардлага хангасан, уул уурхай, металлургийн төрөлжсөн өөрийн гэсэн итгэмжлэгдсэн лабораторитойгоор үйл ажиллагаа явуулж байна.

"Дарханы төмөрлөгийн үйлдвэр" ХХК-ийн Гангийн үйлдвэр нь 1993 оноос эхлэн үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд металлыг даралтаар боловсруулах, цувимал бүтээгдэхүүн үйлдвэрлэх технологи дээр үндэслэгдэн байгуулагдсан Монгол улсын металлургийн салбарын анхдагч болоод хамгийн том үйлдэр юм.

Тус үйлдвэр нь жилд 121.7 мянган тонн хаягдал төмөр хайлж, 108.7 мянган тонн бэлдэц үйлдвэрлэн, 100.0 мянган тонн цувимал бүтээгдэхүүн үйлдвэрлэх хүчин чадалтай ба Япон улсын "Ниссей", "Мицубиши" зэрэг компанийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон үйлдвэр юм.

Бүтээгдэхүүний нэр төрлийг нэмэгдүүлэх, бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх, дотоодын эрэлт хэрэгцээг хангах зорилгоор 2017 онд жилд 25,000 тн давтмал ган бөмбөлөг үйлдвэрлэх хүчин чадалтай, ХБНГУ, Итали улсын тоног төхөөрөмж бүхий ган бөмбөлгийн давтах аргын үйлдвэрийг ашиглалтанд оруулсан.

2025 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн байдлаар Гангийн үйлдвэр нь 28,374.8 тн хаягдал төмөр боловсруулан 29,540.1 тн бэлдэц, 27,863.2 тн цувимал бүтээгдэхүүн үйлдвэрлэж дунджаар 102% хувийн гүйцэтгэлтэй ажилласан байна. Дэлгэрэнгүйг Хүснэгт 1-р харуулав.

# ГАНГИЙН ҮЙЛДВЭРИЙН 2025 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙГ САРААР ХАРУУЛБАЛ

Хүснэгт-1

| № | Үйлдвэрлэл | Ангилал | 1 сар | 2 сар | 3 сар | 4 сар | 5 сар | 6 сар | 7 сар | 8 сар | 9 сар | 10 сар | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хаягдал төмөр худалдан авалт | Тод.Төл, тн | 1,505 | 1,484 | 3,215 | 3,646 | 2,758 | 1,095 | 4,000 | 5,990 | 5,530 | 4,920 | 34,143 |
| | | Гүйцэтгэл, тн | 1,505.0 | 1,483.7 | 3,215.1 | 3,746 | 2,758 | 1,094.8 | 2,509.2 | 2,239.9 | 2,604.4 | 3,250.9 | 24,407.1 |
| | | Төмөр, тн | 1239.4 | 733.1 | 2,467.2 | 2,657.2 | 1,821.1 | 543.6 | 1,688.48 | 1,584.56 | 1,777.0 | 2,227.2 | 16,738.8 |
| | | Шреддер, тн | 0.0 | 587.6 | 275.6 | 490.1 | 584.5 | 466.5 | 531.65 | 277.08 | 362.9 | 538.0 | 4,113.9 |
| | | Ширэм, тн | 265.6 | 163.0 | 472.2 | 598.9 | 352.3 | 84.7 | 289.02 | 378.24 | 464.6 | 485.7 | 3,554.3 |
| | | **Биелэлт, %** | **100%** | **100%** | **100%** | **103%** | **100%** | **100%** | **63%** | **37%** | **47%** | **66%** | **71.5%** |
| 2 | Ачилт | Тод.Төл, тн | 827 | 530 | 2,182 | 2,370 | 3,669 | 328 | 500 | 4,274 | 4,280 | 4,280 | 23,240 |
| | | Гүйцэтгэл, тн | 827.0 | 529.7 | 2,181.8 | 2,370 | 3,669 | 328 | 2,921 | 4,920 | 2,682 | 1,889 | 22,317.3 |
| | | **Биелэлт, %** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **584%** | **115%** | **63%** | **44%** | **96%** |
| 3 | Хаягдал төмөр боловсруулалт | Тод.Төл, тн | 2,912 | 2,383 | 2,583 | 3,449 | 3,246 | 2,632 | 2,332 | 2,632 | 2,533 | 2,733 | 27,435 |
| | | Гүйцэтгэл, тн | 2,912.3 | 2,383.4 | 2,583.4 | 3,448.9 | 3,245.8 | 2,631.6 | 2,639.3 | 2,869.9 | 2,660 | 3,000.6 | 28,374.8 |
| | | Зүссэн төмөр, тн | 2394.7 | 1,992.8 | 2,300.4 | 2,335.2 | 2,181.4 | 1,841.3 | 1,775.6 | 2,115.4 | 2,022.1 | 2,046.3 | 21,005.1 |
| | | Ялгасан төмөр, тн | 178.4 | 66.3 | 28.2 | 229.6 | 221.5 | 32.6 | 276.6 | 341.8 | 52.6 | 200.8 | 1,628.5 |
| | | Ширэм, тн | 339.1 | 324.2 | 254.8 | 464.9 | 437.9 | 355.7 | 208.6 | 270.6 | 410.4 | 369.0 | 3,435.2 |
| | | Пресс, тн | - | - | | 419.2 | 405.1 | 402.0 | 378.5 | 142.2 | 174.7 | 384.4 | 2,306.0 |
| | | **Биелэлт, %** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **113%** | **53%** | **105%** | **110%** | **103%** |
| 4 | Хүчилтөрөгч үйлдвэрлэл KZO-50 | Биз.Төл, тн | 21,790 | 19,840 | 24,173 | 22,887 | 24,987 | 24,287 | 8,400 | | 18,910 | | |
| | | Гүйцэтгэл, м3 | 18,804 | 13,824 | | | | | | | | | |
| | | **Биелэлт, %** | **86%** | **70%** | **0%** | **0%** | **0%** | **0%** | **0%** | | **0%** | | |
| 5 | Бэлдэц үйлдвэрлэл | Тод.Төл, тн | 3,343 | 3,292 | 3,390.2 | 3,356.7 | 3,272.6 | 4,843.8 | 1,630.0 | - | 3,200 | 3,200 | 29,529 |
| | | Гүйцэтгэл, тн | 3,343.0 | 3,292 | 3,390 | 3,357 | 3,273 | 4,844 | 1,635.2 | - | 3,202 | 3,205 | 29,540.1 |
| | | SD390 | - | - | 3,390.2 | 3,356.7 | - | - | - | - | - | | 6,746.9 |
| | | Ст70 | 3,343.0 | 3,292.3 | - | - | 3,272.6 | 4,843.8 | 1,635.2 | - | 3,201.8 | 3,204.6 | 22,793.2 |
| | | **Биелэлт, %** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **100%** | **100%** |
| 6 | Цувимал үйлдвэрлэл | Тод.Төл, тн | 3,000 | 3,000 | 3,000 | 3,000 | 3,000 | 4,000 | 2,000 | - | 3,000 | 2,950 | 26,950 |
| | | Гүйцэтгэл, тн | 3,024.7 | 3,042.7 | 3,187.1 | 3,259 | 3,105 | 4,191 | 2,048 | - | 3,051 | 2,954 | 27,863.2 |
| | | D13 | - | - | 2,146.1 | 1,622.7 | - | - | - | - | - | | 3,768.8 |
| | | D16 | - | - | - | 1,055.0 | - | - | - | - | - | | 1,055.0 |
| | | D19 | - | - | | | - | - | - | - | - | | - |
| | | D22 | - | - | 1,041.0 | - | - | - | - | - | - | | 1,041.0 |
| | | D25 | - | - | - | 535.6 | - | - | - | - | - | | 535.6 |
| | | D29 | - | - | - | - | - | - | - | - | - | | - |
| | | D32 | - | - | - | - | - | - | - | - | - | | - |
| | | R12 | - | - | - | 46.0 | - | - | | - | - | | 46.0 |
| | | **Арматур** | **-** | **-** | **3,187** | **3,259** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **6,446.4** |
| | | R80 | 3,024.7 | 3,042.7 | - | - | 3,104.5 | 2,627.3 | 2,048.1 | - | 3,051.4 | 2,954.4 | **19,853.0** |
| | | R40 | - | | - | - | - | 1,563.8 | | - | - | | 1,563.8 |
| | | **Круг** | **3,025** | **3,043** | **-** | **-** | **3,105** | **4,191** | **2,048** | **-** | **3,051** | **2,954** | **18,462.4** |
| | | **Биелэлт, %** | **101%** | **101%** | **106%** | **109%** | **103%** | **105%** | **102%** | **100%** | **102%** | **100%** | **103%** |

## ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Сөрөг нөлөөллийг бууруулахаар төлөвлөсөн ажил | Сөрөг нөлөөллийг бууруулахаар төлөвлөсөн ажлын биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Агаарын чанарт хяналт тавих, агаар бохирдуулагч бодисын хяналтыг тодорхой төлөвлөгөөний дагуу тогтмол хийх | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан хуваарийн дагуу агаарын шинжилгээг Дархан-Уул аймгийн УЦУОШТ-р гүйцэтгүүлсэн. | - | Шинжилгээний хариуг хавсралт хэсгээс харах |
| 2 | Тээврийн хэрэгслийн сул ажиллагааг хязгаарлах, хяналт тавих, анхааруулах тэмдэг байршуулах | Байгаль орчны инженер өдөр тутмын тойрох үзлэг хийхдээ хяналт тавин ажилласан. Нийтдээ 25 төрлийн 115 ширхэг анхааруулах тэмдэг тэмдэглэгээ шинээр хийж байршуулсан байна. | - | Холбогдох зургийг зураг 8-д харуулав. |
| 3 | Машин механизмуудын яндand шүүлтүүр тавих | Гангийн үйлдвэрийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа бүх машин техник хэрэгслүүд шаардлага хангасан яндангийн шүүлтүүртэй замын хөдөлгөөнд оролцож байна. | 180.000 | |
| 4 | Ил задгай хог шатааж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ил задгай хог шатаалгахгүй байх | Байгаль орчны инженер өдөр тутмын тойрох үзлэг хийхдээ хяналт тавин ажилласан. Ил задгай хог хаягдал шатаасан тохиолдол гараагүй. | | |
| 5 | Хог хаягдлыг тогтмол хугацаанд зайлуулж, ариутгал хийх | НААҮГ-тай байгуулсан “Хог хаягдал ачиж тээвэрлэх, хамтран ажиллах гэрээ”-ний дагуу 250 м.куб хог хаягдлыг ачуулсан байна. Ахуйн хог хаягдлыг ачуулсны дараа хогийн саванд жавелионы уусмал ашиглан ариутгалыг тогтмол хийсэн. | 1.540.655 | Хогийн саванд ариутгал хийсэн тайланг хавсаргав. |
| 6 | Дуу шуугианы хэмжилт хийж, дуу шуугиан бүхий машин механизмын | БО-ны инженер өдөр тутмын тойрох үзлэг хийхдээ хяналт тавин ажилласан. Дуу шуугиан хэмжигч багажаар | - | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | ашиглалтыг оновчтой төлөвлөх, үр ашиггүй ашиглалтыг багасгах | Үйлдвэрийн хашаан дотор, Хашааны гадна талд хэмжилт хийхэд стандарт хэмжээнээс даваагүй үзүүлэлттэй байна. | | |
| 7 | Сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг гэрэлтүүлэг тавих | Үйлдвэрийн хэсэгт сэргээгдэх эрчим хүчээр ажилладаг 2 ш гэрэлтүүлгийг Бэлдэц үйлдвэрлэх цехийн ард байрлах явган хүний замд суурилуулсан. | 700.000 | |
| 8 | Бохир ус дамжуулах хоолойн холбоосуудаар ус алдагдаж байгаа эсэхийг үе үе хянах, тухай бүр нэн даруй засвар хийх | ҮШСЦ-ийн сантехникчид байнгын үзлэг шалгалт хийн хяналт тавин ажилладаг ба засвар үйлчилгээ хийх шаардлага гараагүй. | - | Үзлэг хийж байгаа байдлыг зураг 7-д харуулав. |
| 9 | Үйлдвэрийн орчны хариуцсан талбайг үерийн усны урсацаас хамгаалах зорилгоор далан байгуулах, эвдэрсэн тохиолдолд засварлах | Үйлдвэрээс Төмөр хүн рүү эргэдэг замын хажуугын далан үерийн усанд эвдэрч сэтэрсэн. Сэтэрсэн даланг шороогоор дүүргэж засварласан. | Дотоод зардал | Холбогдох зургийг Зураг 4-д хавсаргав. |
| 10 | Шатах тослох материал алдагдах үед авах яаралтай арга хэмжээг урьдчилан тодорхойлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах | Засварын хэсэг, ШТС-д асгаралтын иж бүрдлийг шинээр худалдан авч хүлээлгэн өгсөн. | Дотоод зардал | Холбогдох зургийг хавсаргав. |
| 11 | Явган зам, зам талбайг шинээр хийх | Ажилчдын тогтмол зорчдог замуудыг үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарсан хаягдал тоосгыг ашиглан засаж сайжруулсан. | Дотоод зардал | Холбогдох зургийг Зураг 2-д хавсаргав. |
| 12 | Шатах тослох материал алдагдах, гэнэтийн ослын үед ашиглах асгаралтын иж бүрдэл, багаж, материал төхөөрөмж бэлэн байлгах | 2 ш асгаралтын иж бүрдлийг засварын граш, ШТС-д байршуулсан. | Дотоод зардал | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 13 | Хог хаягдлыг ангилан ялгаж байх | Үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарсан энгийн хог хаягдлыг цаас, хуванцар, бусад хог хаягдал гэж ангилан ялгаж байна. | Дотоод зардал | Холбогдох зургийг Зураг 4-д хавсаргав. |
| 14 | Хөрсний хяналт шинжилгээг тогтмол хуваарийн дагуу хийх | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгасан хуваарийн дагуу хөрсний шинжилгээг Дархан-Уул аймгийн УЦУОШТөвөөр 4, 10 дугаар сард гүйцэтгүүлсэн. | | |
| 15 | Нефтийн бүтээгдэхүүнээр хөрс бохирлогдсон газарт хөрсийг саармагжуулах арга хэмжээ авах | Асгаралт үүссэн тохиолдолд асгаралтын иж бүрдлийг ашиглан үртсээр хөрсийг хучин саармагжуулж байна. | - | |
| 16 | Үйл ажиллагаа явагдахаас өөр газруудад машин, техник явуулахгүй байх, замын нэгдсэн сүлжээг гаргах | Үйл ажиллагаа явагдахаас өөр газруудад машин, техник явуулахгүй байхад Харуулын алба хяналт тавин ажилласан. Шинээр зам гаргаагүй. | - | |
| 17 | Газрын төлбөрийг үүсгэсэн нэхэмжлэлийн дагуу төлөх | Газрын хэвлий ашигласны төлбөрийг үүсгэсэн нэхэмжлэлийн дагуу бүрэн төлж барагдуулсан. | 27.254.830 | |
| 18 | Нэмэлт ажил | Гангийн үйлдвэрийн терминалд 1ш, авто пүүний хажууд 1ш нийт 2 ш био ОО шинээр худалдан авч суурилуулсан. Гангийн үйлдвэрийн хэмжээнд нүхэн жорлонг ашиглалтаас бүрэн гаргасан. | - | 2024 онд тендер зарлагдаж 2025 онд суурилуулсан. |
| **НИЙТ** | | | **29.675.485** | |

*Зураг 2 Асгаралтын иж бүрдэл*






*Зураг 3 Хог хаягдлын ангилан ялгалт хийж буй байдал*






*Зураг 4 Хаягдал тоосго ашиглан явган хүний зам хийсэн байдал*









*Зураг 5 Шинээр суурилуулсан 2 ш био ОО*

*Зураг 6 Бохир ус дамжуулах хоолойн холбоосуудаар ус алдалтыг шалгаж буй байдал*





*Зураг 7 Анхааруулах тэмдэг байршуулсан байдал*









## ГУРАВ. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Сөрөг нөлөөллийг бууруулахаар төлөвлөсөн ажил | Сөрөг нөлөөллийг бууруулахаар төлөвлөсөн ажлын биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Цэцгийн мандал хийх | Үйлдвэрийн гадна талбайд нийт 200 ш мандлын цэцгийг худалдан авч тарьсан. | 2.000.000 | Холбогдох зургийг хавсаргав. |
| 2 | Шинээр талбайг зүлэгжүүлэх | ҮШСЦехийн урд талын 400 м2 талбай, цайны газрын хажуу талын 120 м2 талбайд зүлэг тарьж усалж арчлан ургуулсан. | 1.000.000 | Шинээр тарьсан зүлгийг зураг 11-д харуулав |
| 3 | Модыг тайрах насжилтыг уртасгах, ургалтыг дэмжих өнгө үзэмжийг сайжруулах | Үйлдвэрийн орчимд тарьсан моднуудад тайралт, таналт хийн ургалтыг дэмжиж, өнгө үзэмжийг сайжруулах ажлыг технологийн дагуу хийсэн. | Дотоод зардал | Холбогдох зургийг зураг 7-д харуулав. |
| 4 | Зүлэгжүүлсэн талбайг услах | Шинээр болон өмнөх жилүүдэд тарьсан зүлгийг услах зорилгоор бороожуулагч худалдан авч суурилуулсан усалгааг өглөө, орой тогтмол хийсэн. | Дотоод зардал | Холбогдох зургийг хавсаргав. |
| 5 | Компанийн “Нэг сая мод” төлөвлөгөөний дагуу мод тарих | Төмөр хүний хойд талд шинээр хашаа барин 250 ш нарс мод тарьсан, Мөн сурын талбайд 70 ш гүйлс, үйлдвэрээс төмөр хүн хүртэл 130 ш гүйлс, 60 ш нарс мод шинээр тарьсан. Нийтдээ 510 ш навчит болон шилмүүст модыг тарьж ургуулж байна. Мөн тарьсан модыг гумины бордоогоор бордож ургалтын хувийг дэмжиж ажилласан. | 2.500.000 | Холбогдох Зургийг хавсаргав. |
| **НИЙТ** | | | **5.500.000** | |

*Зураг 8 Мод сөөгөнд тайралт таналт хийж хэлбэржүүлсэн байдал*



*Зураг 9 Зүлэг тарихаас өмнө*



*10 Зүлэг тарьсны дараа*



*Зураг 11 Гал тогооны хажуу талын шинээр зүлэгжүүлсэн талбай*









*Зураг 12 Цэцгийн мандал хийсэн байдал*





*Зураг 13 Тасалгааны цэцэг шинээр худалдан авч байршуулсан байдал*









*Зураг 14 Төмөр хүний ард шинээр хашаалж мод тарьсан байдал*











## ДӨРӨВ. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн талбай болон түүний нөлөөллийн бүсэд ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйл ба археологийн олдвортой газар байхгүй. Төслийн хэрэгжилтийн явцад ямарваа нэгэн түүх соёлын дурсгалт зүйл олдох үед холбогдох хууль тогтоомжид заасны дагуу засаг захиргааны байгууллага болон холбогдох байгууллага болох ШУА-ын Түүхийн хүрээлэнд даруй мэдэгдэж төслийн үйл ажиллагааг түр хугацаагаар зогсооно.

## ТАВ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Сөрөг нөлөөллийг бууруулахаар төлөвлөсөн ажил | Сөрөг нөлөөллийг бууруулахаар төлөвлөсөн ажлын биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Ажиллагсдыг жилд нэг удаа эрүүл мэндийн үзлэгт хамруулах. | Ажилчдыг урьдчилан сэргийлэх үзлэгийн тендер зарлагдсан байна. | Дотоод зардал | |
| 2 | Ажиллагсдыг хувийн хамгаалах хэрэгслээр хангах, хоргүйжүүлэх нэмэлт бүтээгдэхүүнээр тогтмол хангах | Нийт 1550 ажилтныг улирлын шинж чанараас шалтгаалан хувийн хувцас хамгаалах хэрэгслээр хангаж ажилладаг. Мөн хортой нөхцөлд ажилладаг ажилчдад хор саармагжуулах бүтээгдэхүүнийг сар бүр олгож ажилласан. Өнөөдрийн байдлаар артишок, хар сармис, жанчивлан зэрэг 3 төрлийн 130,000 гаруй бүтээгдэхүүн олгосон байна. | Дотоод зардал | Холбогдох гэрээнүүдийг хавсаргав. |
| 3 | Гал унтраах хэрэгслээр үйлдвэрийг бүрэн хангах арга хэмжээ авах, гал унтраах талаар тодорхой түвшинд бэлтгэлийг хангуулах арга хэмжээ зохион байгуулах | Нийтдээ 150 ш ширхэг гал унтраагуур шинээр худалдан авч цех, нэгжүүдэд олгосон. | Үйл ажиллагааны зардлаас | |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 4 | Байгалийн гамшиг, гэнэтийн ослоос сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, батлуулах | Үйлдвэрийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулан холбогдох төрийн байгууллагаар батлуулсан. | Дотоод зардал | Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хавсаргав |
| **НИЙТ** | | | **Дотоод зардал** | |

*Зураг 15 Батлагдсан гамшгаас хамгаалах төлөвлөгөө*


Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2019 оны ... дугаар сарын ...-ны өдрийн
... дугаар тушаалын гуравдугаар хавсралт

БАТЛАВ
“ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР”ХХК-
ийн ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ................/ Б.ЧАГНААДОРЖ /

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН НУТАГТ ОРШИХ
“ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР” ХХК ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

ХЯНАСАН: ГАМШГААС ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨЛТ БЭЛЭН БАЙДАЛ ХАРИУЦСАН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН, ГАМШГААС ХАМГААЛАХ УЛСЫН ХЯНАЛТЫН
БАЙЦААГЧ АХМАД..........................................Б.ТҮВШИНТӨР

ХЭМАББОХ-ийн дарга..........................................Н.БАТЦЭНД

ХЭМАББОХ-ИЙН АХЛАХ ИНЖЕНЕР..........................Э.БАЯРСАЙХАН

ДАРХАН-УУЛ АЙМАГ

2025 ОН

## ЗУРГАА. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Сөрөг нөлөөллийг бууруулахаар төлөвлөсөн ажил | Сөрөг нөлөөллийг бууруулахаар төлөвлөсөн ажлын биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | НААҮГ-тай гэрээ байгуулан ачилтыг хугацаанд нь хийлгэх | Дархан-Уул аймгийн НААҮГ-тай гэрээ байгуулан, энгийн хог хаягдлыг долоо хоног бүрийн пүрэв гаригт ачуулж байна. | 1.540.000 | Хог хаягдлын гэрээ болон хог хаягдал ачуулж буй зургийг хавсаргав. |
| 2 | Хог хаягдлыг ангилан ялгаж түр хадгалах, дахин боловсруулах боломжтой хогийг зөвшөөрөлтэй газар нийлүүлэх | Хаягдал бээлий, хуванцар хог хаягдлыг ангилан хаях дадлыг хэвшүүлсэн.<br>Хуванцар хог хаягдлыг “SESL” ХХК-тай гэрээ байгуулан дахин боловсруулалтад өгч байна.<br>Үйлдвэр, уурхайн хэмжээнд хуримтлагдсан 3350 дугуй, 120 аккумляторыг “Талст орд” ХХК-д гэрээний дагуу нийлүүлсэн. | Дотоод зардал | Холбогдох зургийг хавсаргав. |
| 3 | Нийтийн эзэмшлийн талбай, үйлчилгээний орчинд болон хариуцан хамгаалах талбайн орчинд хогийн сав байрлуулах | Гангийн үйлдвэрийн хэмжээнд нийт 240 л, 360 л, 600 литрийн багтаамжтай 56 ш хогийн савыг цехүүдэд шинээр олгож байршуулсан. | 19.900.000 | Зураг 15-д хогийн савын зургийг хавсаргав |
| 4 | Хог хаягдлыг дахин боловсруулах | Технологийн хаягдлын талбайгаас металл хэсгийг ялган авах ажил хийгдэж 150 орчим тн металлыг хаягдал шаарнаас ялган авч үйлдвэрлэлд эргүүлэн ашигласан | - | Гэрээ, актыг хавсаргав. |
| 5 | Технологийн хаягдлуудыг холилдож, | Үйлдвэрийн технологиос гарах | - | Холбогдох мэдээллийг |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | хөрс бохирдуулахаас сэргийлж тусад нь хадгалах | хаягдал шаар, зэв, тоосго, уутан фильтер зэргийг тус тусад нь хадгалж, гарсан тоо хэмжээ бүрээр бүртгэл хөтлөн ажилласан. | | Хуудас 25-с харна уу. |
| 6 | Хаягдал төмөртэй хамт аюултай хог хаягдал орж ирэхгүй байхад тогтмол хяналт тавьж ажиллах | “Хаягдал төмөр хүлээн авах” журмын дагуу хаягдал төмөртэй хамт аюултай хог хаягдал оруулахгүй байхад Чанар хяналтын хэлтсээс хяналт тавин ажиллаж байна. | - | Холбогдох журмыг хавсаргав |
| 7 | Эмнэлгийн хог хаягдлыг мэргэжлийн байгууллагад өгч устгуулах | АШТҮХ-с гарах аюултай хог хаягдлыг аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй гэрээ байгуулан долоо хоног бүрийн Мягмар гарагт устгалд өгч тайланг сар бүр маягтын дагуу гаргаж байна. Өнөөдрийн байдлаар нийт 113,9 кг хог хаягдлыг устгуулсан байна. | 2.278.00 | Эмнэлгийн хог хаягдал устгуулахаар өгч буй зургийг Зураг 17-д хавсаргав. |
| 8 | Химийн аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагад өгч устгуулах | Химийн бодисын аюултай хог хаягдлыг “Элемент” ХХК-тай гэрээ байгуулан устгуулсан. Нийтдээ 327,23 кг химийн бодисын хаягдал шил сав, хаягдал бээлий зэргийг устгуулаад байна. | 4.242.992 | Устгалын актыг хавсаргав. |
| 9 | Ашигласан тос маслыг мэргэжлийн байгууллагад өгч устгуулах | Үйлдвэр, уурхайн хэмжээнд түр хадгалагдаж байгаа ашигласан тос маслыг “Төгсбилэг инженеринг” ХХК-тай байгуулсан гэрээний | 1.350.000 | Гэрээ, актыг хавсаргав. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | дагуу устгуулсан. Үйлдвэрийн хэмжээнд нийт 4.3 тонн хаягдал тосыг устгуулаад байна. | | |
| 10 | Аюултай хог хаягдлын бүртгэл хөтөлж, хяналт тавих | Батлагдсан бүртгэлийн маягтын дагуу гарах хог хаягдлын төрөл тус бүрээр нь бүртгэл хөтлүүлэн холбогдох нэгжүүдээс сар бүр хог хаягдлын мэдээг авч ажилласан. | - | Холбогдох зургийг хавсаргав. |
| 11 | Нэмэлт | Долоо хоног бүрийн Пүрэв гарагт бүх нийтийн цэвэрлэгээний өдөр болгон нэгж хэсгүүд хуваарьт талбайгаа цэвэрлэж хэвшсэн | - | Цэвэрлэгээ хийж буй зураг, цэвэрлэгээний тайланг хавсаргав. |
| 12 | | Гүйцэтгэх захирлын 2025 оны 01 тоот албан даалгаврын дагуу Сард 1 удаа бүх ажилтныг хамруулсан бүх нийтийн цэвэрлэгээг зохион байгуулж ажилласан. | Дотоод зардал | Цэвэрлэгээ хийж буй зураг, цэвэрлэгээний тайланг хавсаргав. |
| **НИЙТ** | | | **29.310.992** | |

**Хог хаягдлын бүртгэлийн код**

295

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАР

Монгол банкны байрны II давхар, 14 дүгээр баг,
Дархан сум, Дархан-Уул аймаг, 45059
Утас/Факс: (976) 7037-3456
Цахим шуудан: daboajg@gmail.com

2025.02.12 № 45

танай ______ -ны № ______ -т

ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР ТӨХК-Д

Танай байгууллагын мэдээллийг цахим мэдээллийн системд бүртгэж, Хог хаягдлын тухай хуулийн 5-р бүлэг "Аюултай хог хаягдлыг савлах, түр хадгалах, тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах" талаар 21.1-т заасанаар Аюултай хог хаягдал үүсгэгч болон аюултай хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь энэ хуулийн 8.1.9.а-д заасны дагуу бүртгүүлж, бүртгэлийн дугаар авсан байна гэж заасны дагуу 002028 код олгов.

ДАРГА Г.БАТБАЯР

Тоот А5

**Хог хаягдлын тайланг холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлж ажиллалаа.**

DMP

ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР
ХЯЗГААРЛАГДМАЛ ХАРИУЦЛАГАТАЙ КОМПАНИ

16 дугаар баг, Дархан сум, Дархан-Уул аймаг, 45045
Утас/Факс: (976) 7555-0011
Цахим шуудан: info@dmp.mn
Цахим хуудас: www.dmp.mn

2025.01.17 № 02/118

танай ______ -ны № ______ -т

ДАРХАН СУМЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА Б.БАТЗУЛ ТАНАА

"Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ХХК-ийн аюултай хог хаягдлын 2024 оны тайланг /БОХ-6.2/ маягтын дагуу гаргаж хүргүүлэв.

Хавсралт 1 хуудастай.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР БӨГӨӨД ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.ХИШИГБАЯР

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

4525030421

**Хаягдал тос нийлүүлэх гэрээ**

БАТЛАВ
"ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР"
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.ЧАГНААДОРЖ

БАТЛАВ
"ТӨГСБИЛЭГ ИНЖЕНЕРИНГ"
ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
О.ЛХАГВАДОРЖ

"ХИМИЙН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, УСТГАХ ҮЙЛЧИЛГЭЭ АЖИЛ" АЖИЛ ГҮЙЦЭТГҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар № DMP-2025-06-45

2025 оны 04-р сарын 29-ны өдөр Дархан-Уул аймаг

Нэг талаас **"Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ХХК /РД:2051303/** (цаашид "Захиалагч" гэх) нь нөгөө талаас **"Төгсбилэг инженеринг" ХХК /РД:5652049/** (цаашид "Гүйцэтгэгч" гэх)-ийн ирүүлсэн тендерийг хүлээн зөвшөөрч энэхүү гэрээг дараах нөхцөлөөр байгуулав.

Энэхүү гэрээ нь Захиалагч болон Гүйцэтгэгчийн хооронд ажил гүйцэтгэх, дагалдах үйлчилгээ үзүүлэх (цаашид хамтад нь "Ажил" гэх) болон үнэ төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1. Энэ гэрээний дагуу гүйцэтгэх **"Химийн аюултай хог хаягдал хадгалах, тээвэрлэх, устгах үйлчилгээ ажил"**-ын үнэ нь **8,400,000 */Найман сая дөрвөн зуун мянган/*** төгрөг (цаашид "гэрээний үнэ" гэх) байна. Гэрээний үнэ нь санхүүжилтийн дээд хэмжээ байна. НӨАТ орсон үнэ болно.

| № | Бараа, ажил, үйлчилгээний нэр | Гүйцэтгэх ажил | ХН | ТХ | Нэгж үнэ /төгрөг/ | Нийт үнэ /төгрөг/ |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Химийн аюултай хог хаягдал хадгалах, тээвэрлэх, устгах үйлчилгээ ажил | Үйлдвэр, уурхайн хэмжээнд хуримтлагдсан 23 тонн аюултай хог хаягдал болох хаягдал тос масло дахин боловсруулах | литр | 23,000 | 300 | 6,900,000 |
| | | Тээвэрлэлт | давтамж | 1 | 1,500,000 | 1,500,000 |
| | **Нийт дүн** | | | | | **8,400,000** |

2. Гэрээний үнийг Гүйцэтгэгч **"Төгсбилэг инженеринг" ХХК**-ийн харилцах Хаан банкны **5111691064** дугаарын дансанд шилжүүлнэ.
3. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно. (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:
   - 3.1. Гэрээ байгуулах зөвшөөрөл;
   - 3.2. Нийлүүлэгчийн ирүүлсэн үнийн санал;
   - 3.3. Гэрээний тусгай нөхцөл;
   - 3.4. Гэрээний ерөнхий нөхцөл;
   - 3.5. Ажил гүйцэтгэх хуваарь;
4. Гэрээний хэрэгжилттэй холбоотой асуудлаар талуудыг дараах эрх бүхий этгээдүүд төлөөлнө. Үүнд:
   - 4.1. Захиалагчийн төлөөлөгчийн мэдээлэл
     Овог, нэр: **Д.Доржсүрэн**
     Албан тушаал: **Худалдан авалтын хэлтсийн дарга**
     Холбогдох утас:**7509-0044**

2025-06-45

**Эмнэлэгийн хог хаягдал нийлүүлэх гэрээ**

БАТЛАВ, ДАРХАН-УУЛ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ЭМЧ
Б.МӨНХБАТ

БАТЛАВ, "ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Б.ЧАГНААДОРЖ

ЭМНЭЛГИЙН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫГ ЦУГЛУУЛАХ, ХАДГАЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ХАЛДВАРГҮЙТГЭХ УСТГАХ ГЭРЭЭ

2025 оны 03 сарын 13-ны өдөр № 200325/01 Дархан-Уул аймаг

**Нэг. Гэрээний үндэслэл**

Эрүүл мэндийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн А/505 тоот тушаал, Сангийн сайд, ЭМС-ын хамтарсан 2022 оны 02-р сарын 28-ны өдрийн 49/А/118 тоот тушаалын Төрийн болон орон нутгийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас бусад эрүүл мэндийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага болон иргэнд үзүүлэх нэмэлт үйлчилгээний жагсаалтыг тус тус үндэслэн хэрэгжүүлэх зорилгоор байгуулав.

**Хоёр. Гэрээний зорилго**

Дархан-Уул аймагт үйл ажиллагаа явуулж буй Эрүүл мэндийн байгууллагуудын хог хаягдлыг цуглуулах, ангилах, тээвэрлэх, устгах, иргэний эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах зорилготой.

Энэхүү гэрээ нь нэг талаас Дархан Нэгдсэн эмнэлэг (цаашид гүйцэтгэгч гэх)-г хог хаягдлыг цуглуулах, хадгалах, тээвэрлэх, халдваргүйтгэж устгах, Нөгөө талаас "Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ХХК **РД2051303** (цаашид захиалагч) нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

**Гурав. Захиалагч талын эрх үүрэг**

3.1. Үйл ажиллагаанаас гарах боолтын материал, хэрэглэсэн зүү тариур, бээлий, толь тарианы шил, хамгаалах хувцас хэрэгсэл, бусад эмнэлгийн гаралтай аюултай хог хаягдлыг зохих журам заавын дагуу зориулалтын аюулгүй хайрцаг, шар уутанд хийж Нэгдсэн эмнэлгийн устгалд өгнө.

3.2. Долоо хоногийн Пүрэв гаригт өдрүүдэд аюултай хог хаягдлаа стандартын дагуу бэлдэж бэлэн болгосон байх

3.3. Хог хаягдлын тээврийн хэрэгсэл очиход хүлээгдэл үүсэхгүй, холбоо барих утас бичсэн байх

3.4. Захиалагч тал баглаа боодлыг өөрсдөө хангаж бэлдэнэ.

3.5. Гэрээний үнэ кг нь 20,000 /хорин мянга/ төгрөг.

3.6. Төлбөрийг гэрээ хийхдээ сар, улирлаар Төрийн сан банк /**100190020002**/ -дансанд, эсвэл кассад тушаасан байх

*Зураг 16 Химийн бодисын аюултай хог хаягдал устгасан акт*

**ХИМИЙН БОДИСЫН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ**

**ХҮЛЭЭЛГЭН ӨГСӨН АКТ**

2025 оны 08-р сарын 15-ны өдөр № 25/*01* Дархан-Уул аймаг

Хүлээлгэн өгч буй байгууллга: **"Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ХХК**

Хүлээн авагч байгууллага: **"Элемент" ХХК**

Гэрээний дугаар: ХБ-25 /10/ **DMP-2025-06-57**

| № | Нэр төрөл | Хэмжих нэгж | Хаягдлын хэмжээ |
|---|---|---|---|
| 1 | Химийн бодисын хатуу хог хаягдал | кг | 168,53 |
| 2 | Химийн бодисын хоосон шилэн сав | кг | 66,20 |
| 3 | Химийн бодисын хоосон хуванцар сав | кг | 58,80 |
| 4 | Химийн бодистой харьцан ажиллагсдын маск , бээлий | кг | 33,70 |
| | **НИЙТ** | **кг** | **327,23** |

Хүлээлцсэн:

**"Элемент" ХХК-ийг төлөөлж:**

Жолооч:
........................ / Ж.Сүхбат /
Утас: 80822211

........................ / С.Батсүрэн /
Утас: 86053790

Машин: 37-95 УКУ Dayun

*/Тамга, тэмдэг/*
Харилцах утас: 88103666, 99107745
Хаяг: Налайх дүүрэг 3-р хороо, Бүс нуур /12610/

**"Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр" ХХК-ийг төлөөлж:**

Чанар хяналтын хэлстийн дарга
........................ / Б.Батбүрэн /
Утас: 99032320

Лаборатори судалгааны төвийн дарга
........................ / Л.Нэргүй /
Утас: 99002128

БОХАБЭАХ-н байгаль орчны инженер
......................../Л.Өлзийхишиг/
Утас: 99757693

Дотоод хяналтын хэлтсийн хяналт үнэлгээний мэргэжилтэн
........................ / Б.Титэм /
Утас: 99270432

Хамгаалалт, аюулгүй байдлын албаны дарга
........................ / Д.Энхтөр /
Утас: 99103144

*/Тамга, тэмдэг/*
Хаяг: Дархан-Уул аймаг, Дархан сум 16-р баг, үйлдвэрийн район

*Зураг 17 Эмнэлэгийн аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллагад өгч устгуулж буй байдал*







*Зураг 18 Хаягдал тосыг мэргэжлийн байгууллагад нийлүүлж буй байдал*





*Зураг 19 Үйлдвэрийн хэмжээнд эхний ээлжийн хаягдал тос ачуулсан мэдээ*

**"ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР" ХХК "ТӨГСБИЛЭГ ИНЖЕНЕРИНГ" ХХК МЭРГЭЖЛИЙН БАЙГУУЛЛАГАТАЙ БАЙГУУЛСАН ГЭРЭЭНИЙ ДАГУУ ХАЯГДАЛ ТОС, МАСЛО НИЙЛҮҮЛСЭН МЭДЭЭНИЙ НЭГТГЭЛ**

2025.05.21

| № | Хаана | Хэмжих нэгж | 2025.04.29 | 2025.04.30 | 2025.05.03 | 2025.05.14 | Нийт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Үйлдвэр | Литр | | 1000 | 3350 | | 4350 |
| 2 | Төмөртэй уурхай | Литр | 18500 | | | 10000 | 28500 |
| 3 | Төмөртолгой | Литр | | | | 13050 | 13050 |
| **Нийт** | | | **18500** | **1000** | **3350** | **23050** | **45900** |

Нэгтгэл гаргасан:

БО-ны ахлах инженер Л.Өлзийхишиг

*Зураг 20 Аюултай хог хаягдлын дагалдах бичиг*

Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн А/21 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт

**АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДЛЫН ДАГАЛДАХ БИЧИГ**

Дагалдах бичгийн дугаар:
(шаардлагатай тохиолдолд нэмэлт хуудас хэрэглэ)

**1. Үүсгэгчийн талаарх мэдээлэл:**
Бүртгэлийн дугаар: Ү
Нэр: Дарханы төмөрлөгийн үйлдвэр ХХК.

**2. Аюултай хог хаягдлыг хүлээлгэн өгсөн:**
Овог нэр (дармал үсгээр бичих): Э.Мөнхмягмар | Гарын үсэг (тамга) | он 2025 | сар 05 | өдөр 14

**3. Тээвэрлэгчийн талаарх мэдээлэл:**
1/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар: 8413 УНК Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар:
Тээвэрлэгч аж ахуйн нэгжийн нэр: Төгсбилэг инженеринг ХХК
2/ Тээврийн хэрэгслийн улсын дугаар: — Тээвэрлэгчийн бүртгэлийн дугаар:
Тээвэрлэгч аж ахуйн нэгжийн нэр: —

**4. Аюултай хог хаягдлын талаарх мэдээлэл:**

| № | Аюултай хог хаягдлын нэр | Аюулын ангилал | Савал-гааны бүлэг | Савны дугаар | Савны төрөл | Хэмжээ | Нэгж (кг эсвэл л) | Аюултай хог хаягдлын код |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Хаягдал моторын тос | А | — | - | - | 10000 | л | 130202 |
| 2 | | | | | | | | |
| 3 | | | | | | | | |
| 4 | | | | | | | | |

**5. Тээвэрлэх үед анхаарах нэмэлт зааварчилгаа, мэдээлэл:**

**6. Аюултай хог хаягдлыг хүлээн авсан тээвэрлэгч:**
1 Овог нэр (дармал үсгээр бичих): Г.Оюунбаатар | Гарын үсэг | он 2025 | сар 05 | өдөр 14
2 Овог нэр (дармал үсгээр бичих): — | Гарын үсэг | он | сар | өдөр

**7. Үл зохицол**

**8. Аюултай хог хаягдлыг хүлээн авагчийн талаарх мэдээлэл:**
Аж ахуйн нэгжийн нэр: Төгсбилэг инженеринг ХХК
Бүртгэлийн дугаар:
Аюултай хог хаягдлыг хүлээн авсан:
Овог нэр (дармал үсгээр бичих) | Гарын үсэг (тамга) | он | сар | өдөр

1117138217
УХА0579 9085084

БҮХ НИЙТИЙН ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙСЭН БАЙДЛЫГ ЗУРГААР ХАРУУЛБАЛ





*Цэвэрлэхээс өмнө- Зураг 21*





*Цэвэрлэсний дараа – Зураг 22*

## БҮХ НИЙТИЙН ЦЭВЭРЛЭГЭЭ ХИЙСЭН БАЙДЛЫГ ЗУРГААР ХАРУУЛБАЛ




*Цэвэрлэхээс өмнө – Зураг 23*




*Цэвэрлэсний дараа- Зураг 24*

*Зураг 25*

| Цэвэрлэхээс өмнө | Цэвэрлэсний дараа |
|---|---|
|  |  |
|  |  |

Цэвэрлэгээ хийсэн байдал – Зураг 26









*Зураг 27 Хогийн сав байршуулсан байдал*






240 литртэй хогийн сав

600 литртэй хогийн сав



# ДОЛОО. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

| Д/д | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | **Агаарын чанар:**<br>$O_2$, $SO_2$, CO, NH3, нийт тоос,<br>PM2.5, PM10,<br>Дэгдэмхий бодисуудыг тодорхойлох,<br>Үйлдвэр орчмын дуу чимээ | -Уутан фильтерийн орчим<br>-Дизель түлшний агуулах<br>-Төмөр бэлтгэх цех<br>-ШТС-ийн орчим<br>-Азотын хий ялгарч байгаа хэсэг<br>-Химийн бодис хадгалах тусгай өрөө<br>2025 оны 04, 07, 10 саруудад Дархан-Уул аймгийн УЦУОШТөвөөр хийлгэсэн | 3.945.000 | Шинжилгээний дүнг “Хавсралт” хэсгээс харна уу. |
| 2 | **Хөрсний төлөв байдал, бохирдол:**<br>Хөрсний морфологи бичиглэл, pH, ЦД давс %, ялзмагийн агууламж, шим тэжээлийн элемент /$NO_3$, $P_20_5$, $K_20$ хөрсний механик бүрэлдэхүүн, нүүрс ус төрөгчийн нэгдлүүд, Хүнд металлын шинжилгээ (K, Ca, Ti, Cr, Mn, Fe, Co, Cu, Zn, As, Se, Sr, Pb, Hg, S, Cl,) тодорхойлох | -Засварын төв<br>-Түүхий эд хүлээн авах цэг<br>-Түүхий эд жижиглэх<br>-Түүхий эдийн хуримтлалын цэг<br>-Төв замаас үйлдвэрийн хашааны хаалга хүрэх замд цэг сонгож pH, ЦДЧ, ялзмаг, $NH_4$, $NO_3$, $SO_4$ болон хүнд металл үзүүлэлтүүдээр 2025 оны 7, 10 сард аймгийн УЦУОШТөвөөр хийлгэсэн. | | Бүх цэгүүдэд хөрсний химийн үзүүлэлт стандартаас давсан үзүүлэлтгүй байна. Шинжилгээний дүнг “Хавсралт” хэсэгт хавсаргав. |
| 3 | **Усны хяналт шинжилгээ:**<br>pH, уусСан давс, хатуулаг, Ca, Mg, Na, K, $SO_4$ , NO2, NO3, NH4, As, Cd, Cu, Hg, Pb, Zn, Cr, Fe, Ni, үнэр, өнгө,<br>- Нянгийн шинжилгээ<br>- Бохир усны шинжилгээ | - Гал тогооны төвийн цэвэр усны хэсэг<br>- Хаягдал ус нийлүүлэх хэсэгт 2025 оны 4, 7, 10 дугаар саруудад Дархан-Уул аймгийн УЦУОШТөвөөр шинжилгээ хийлгэсэн | | Бүх цэгүүдэд шинжилгээний дүнгээр стандартаас давсан үзүүлэлтгүй байна. |
| 4 | **Хаягдал зэв, шаар шинжилгээ хийлгэх:** | Технологийн хаягдлын талбайгаас 2025 оны 7, 9 сард Дархан-Уул аймгийн | | Шинжилгээний дүнг хавсралт хэсгээс харах. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | NNP, AP, NP/AP, S-NXS, S-Pyr, S-SO4, S-tot, S-HCI, NAG test | УЦУОШТөвөөр шинжилгээ хийлгэсэн. | | |
| **НИЙТ** | | | **3.945.000** | |

*Зураг 28 Шинжилгээ хийж буй байдал*









## НАЙМ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Төлөвлөсөн арга хэмжээ | Төлөвлөгөөний биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Ажилчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалт зохион байгуулах | Нийт 1500 гаруй ажилтан албан хаагчдад хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны сургалтыг мэргэжлийн байгууллагаар зохион байгууллуулсан. | Дотоод зардал | Сургалт орж буй зураг болон сургалтын агуулгыг хавсаргав. |
| 2 | Байгаль орчныг хамгаалах талаар сургалт зохион байгуулах, холбогдох орон нутгийн байгаль орчны алба болон байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах | “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХХК”-ийн шинээр батлагдсан “Байгаль орчны журам”-ыг Төмөртолгой уурхайн 48 ажилтан, Гангийн үйлдвэрийн “Төмөр бэлтгэх цех”-ийн 54 ажилтанд тус тус танилцуулсан.<br>Мөн бүх ажилтны ХАБ-ын байгаль орчны танин мэдэхүйн булан гаргаж хог хаягдлаас үүсэх эрсдэл, усны зүй зохистой хэрэглээний талаар мэдээлэл бэлтгэн танилцуулж ажилласан. | Дотоод зардал | Сургалтын талаарх дэлгэрэнгүйг тайлангийн 2 дугаар бүлгийн 16 дахь хэсгээс харна уу. |
| 3 | Байгаль орчныг хамгаалах жилийн тайланг орон нутгийн засаг захиргаанд цаг тухайд нь гаргаж өгч байх | 2025 оны БОМТ-ний биелэлтийн тайланг Дархан-Уул аймгийн БОГ-т хуулийн хугацаанд хүргүүлсэн. | Дотоод зардал | - |
| 4 | Байгаль орчны удирдлагын тогтолцоо ISO14001:2015 стандартыг үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх ажлыг эхлүүлэх | Байгаль орчны менежментийн тогтолцоо ISO 14001:2015 олон улсын стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж гэрчилгээг гардаж авсан. Ингэснээр нэгдсэн менежментийн тогтолцоогоор олон улсын шаардлагыг хангаж, дунд болон урт | Дотоод зардал | Холбогдох зургийг хавсаргав. |

| | | | | |
|---|---|---|---|---|
| | | хугацааны бодлого, тогтвортой хөгжлийн зарчимд нийцсэн үйл ажиллагаа явуулах зорилт тавин ажиллаж байна. | | |
| 5 | Байгаль орчны нийцлийн аудит хийлгэх | Гангийн үйлдвэрийн төлөвлөгөөг байгаль орчны аудитыг Тэрх хүрэмт ХХК-иар хийлгэж хүлээж авсан. | 19.800.000 | Хавсралттаас харах |
| 6 | Нэмэлтээр хийгдсэн ажил | “Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК-ийн “Байгаль орчны журам”-ыг боловсруулан Гүйцэтгэх захирлын 2025 оны А/157 дугаар тушаалаар батлуулж ажилласан. Журмыг бүх ажилтанд танилцуулахаар цахим системд байршуулсан бөгөөд цех хэсэг нэгж бүрээр очиж танилцуулга хийж ажиллаж байна. | | |
| **НИЙТ** | | | **19.800.000** | |

*Зураг 29 Байгаль орчны менежментийн тогтолцоо ISO 14001:2015 стандартыг нэвтрүүлж гэрчилгээ гардан авч буй байдал*



*Зураг 30 Байгаль орчны нийцлийн аудитын тайлан*



РД: 2051303

АУДИТ ГҮЙЦЭТГЭГЧ:
ТЭРХ ХУРЭМТ ХХК

ЗАХИАЛАГЧ:
"ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР" ХХК

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН НУТАГТ БАЙРЛАХ "ГАНГИЙН ҮЙЛДВЭР" -ИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ НИЙЦЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Байгаль орчны аудитын багийн гишүүд:

| Д/д | Овог, нэр | Албан тушаал | Гарын үсэг |
|---|---|---|---|
| 1 | Х.Бадарч | Захирал | |
| 2 | Б.Даваажаргал | Ахлах аудитор | |
| 3 | Ц.Дайваа | Аудитор | |
| 4 | Д.Пүрэвдаш | Аудитор | |

*Зураг 31 Батлагдсан байгаль орчны журам*



"ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР" ХХК

ҮЙЛДВЭРЛЭЛ ТЕХНОЛОГИЙН ГАЗАР

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЖУРАМ
(ДТҮ-ЖУ/25 – 17 – 01 – 036)

Баталсан огноо: 2025 оны 03 сарын 20 өдөр

Тушаалын дугаар: А/157 дугаар тушаалын 1-р хавсралт

Мөрдөж эхлэх огноо: 2025 оны 03 сарын 20 өдөр

Баримт бичгийн хариуцагч: ХЭМАБЬБОХ

*Зураг 32 Байгаль орчны журмын танилцуулга хийж буй байдал*



*Зураг 33 Бүх ажилтны ХАБ-ын сургалт*












## ЕС. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД, ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | БОМТ-ний биелэлтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчидад тайлагнах төлөвлөгөө | БОМТ-ний биелэлтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчидад тайлагнах төлөвлөгөөний биелэлт | Зардал, төгрөг | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Дархан-Уул аймгийн Засаг даргын тамгын газар | БОМТ биелэлтийн тайланг Дархан-Уул аймгийн БОГ-т хүргүүлсний дараа тайлан хамгаалах хугацааг товлох ба тогтоосон хугацаанд тайланг хамгаална. | - | |
| 2 | Нөлөөлөлд өртөгч оршин суугчид | “Дэлхийн усны өдөр”-ийг тохиолдуулан Дархан сумын ЗДТГазартай хамтран ЕБСургуулийн сурагчдын дунд “Усаа хэмнэе” видео контентын уралдааныг зохион байгуулсан.<br>Тус контентын уралдаанд нийт 13 бүтээл ирснээс 1-7 дугаар ангийн ангилалд эхний 3 байр, 8-12 дугаар ангийн ангилалд эхний 3 байр нийт 6 байрыг шалгаруулж өргөмжлөл мөнгөөр шагналаар шагнасан байна. Тус контентийн уралдааны шагналд 2.000.000 төгрөгийн төсвийг зарцуулсан байна. | 2.000.000 | |
| 3 | БОУАӨЯамны ХБОБНУ-ны | Гангийн үйлдвэрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг холбогдох журмын дагуу урьдчилсан байдлаар боловсруулж 2025 оны 11 дүгээр сарын 1-ны дотор eic.mn сайтад байршуулж ажиллалаа. | - | |
| Нийт | | | **2.000.000** | |

# “ДЭЛХИЙН УСНЫ ӨДӨР”-ИЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ БАТЛАГДСАН ТӨЛӨВЛӨГӨӨ

БАТЛАВ:
ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР
ХХК-ИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН
ГАЗРЫН ДАРГА Г.ХИШИГБАЯР

БАТЛАВ:
ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Б.МӨНХ-ЭРДЭНЭ

**“ДЭЛХИЙН УСНЫ ӨДӨР”-ИЙГ ТОХИОЛДУУЛАН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**

2025.03.21

**Зорилго:**

Жил бүрийн 3 дугаар сарын 22-нд Дэлхий нийтээр тэмдэглэн өнгөрүүлдэг “Дэлхийн усны өдөр”-ийн хүрээнд усны үнэ цэнэ, хамгаалалт, тогтвортой хэрэглээг олон нийтэд болон байгууллагын ажилтан, албан хаагчдад сурталчлан таниулах

**Зорилт:**

1. ЕБС-ийн сурагчдын дунд ус, усны нөөц, усны үнэ цэнэ, усны өдөр тутмын зөв зохистой хэрэглээний талаарх мэдлэгээ видео контентоор дамжуулан илэрхийлэх, бусдыг уриалах, нийгэмд эергээр нөлөөлөх боломжийг олгох
2. Усыг зүй зохистой хэрэглэх талаарх танин мэдээллийн хуудас стикер хэвлүүлж шардлагатай газруудад байршуулах

**Хүрэх үр дүн:**

Усны нөөцийг хамгаалах, зүй зохистой, хэмнэлттэй ашиглах, бохирдохоос сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахын тулд шинэ санаачлага, шийдлүүдийг таниулан сурталчилснаар усны хэрэглээний зөв дадал зуршлыг бий болгож, нийгэмд эергээр нөлөөлөх нөлөөллийг бий болгосон байна.

| № | Ажлын нэр | Хугацаа | Хариуцах эзэн | Хамтран хэрэгжүүлэх |
|---|---|---|---|---|
| 1 | Дархан сумын ЗДТГазартай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд “Усаа хэмнэе” сэдэвт видео контентын уралдаан зохион байгуулах | 2025.03.20 2025.03.26 | ХЭМАББОХ ХАХ | Дархан сумын ЗДТГ |
| 2 | “Усаа хэмнэе” видео контентын уралдааныг дүгнэх | 2025.03.27 | ХЭМАББОХ ХАХ | Дархан сумын ЗДТГ |
| 3 | Усыг зүй зохистой ашиглах, талаарх мэдээллийн хуудас стикер хэвлүүлж шаардлагатай газруудад байршуулах | 2025.03.21 2025.03.24 | ХЭМАББОХ | ХАХ |
| 4 | “Усаа хэмнэе” видео контентын шилдгүүдэд шагнал гардуулах | 2025.03.28 | ҮТГ-ын дарга, Дархан сумын Засаг даргын орлогч | Дархан сумын ЗДТГ |
| 5 | Дэлхийн усны өдрийн хүрээнд зохион байгуулсан ажлын тайланг нэгтгэн ХЕГСГЗахиргаанд хүргүүлэх | 2025.03.29 | ХЭМАББОХ | |

ХЯНАСАН:
ХЭМАББОХ-ИЙН ДАРГА Н.БАТЦЭНД
ХаАХ-ИЙН ДАРГА В.ЦЭНДЖАВ

ТӨЛӨВЛӨГӨӨ ГАРГАСАН:
БО-НЫ АХЛАХ ИНЖЕНЕР Л.ӨЛЗИЙХИШИГ

# УСАА ХЭМНЭЕ ВИДЕО КОНТЕНТЫН УДИРДАМЖ

БАТЛАВ.
“ДАРХАНЫ ТӨМӨРЛӨГИЙН ҮЙЛДВЭР”
ХХК-ИЙН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН
ГАЗРЫН ДАРГА Г.ХИШИГБАЯР

БАТЛАВ.
ДАРХАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ Б.МӨНХ-ЭРДЭНЭ

**“УСАА ХЭМНЭЕ” ВИДЕО КОНТЕНТИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ**

**ҮНДЭСЛЭЛ**

“Дэлхийн усны өдөр”-ийг тохиолдуулан усны нөөцийг хамгаалах, зүй зохистой, хэмнэлттэй ашиглах, бохирдохоос сэргийлэх, уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахын тулд шинэ санаачлага, шийдлүүдийг таниулан сурталчилснаар усны хэрэглээний зөв дадал зуршлыг бий болгох, нийгэмд эергээр нөлөөлөх зорилготой.

**ЗОРИЛГО**

Тус уралдаан нь ЕБС-ийн сурагчдын дунд ус, усны нөөц, усны үнэ цэнэ, усны өдөр тутмын зөв зохистой хэрэглээний талаарх мэдлэгээ видео контентоор дамжуулан илэрхийлэх, бусдыг уриалах, нийгэмд эергээр нөлөөлөх боломжийг олгох зорилгоор тус уралдааныг зохион байгуулж байна.

**ЗОХИОН БАЙГУУЛАГЧ**

- Дархан сумын Засаг даргын Тамгын газар
- Хараа-Ерөө голын сав газрын захиргаа
- Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХХК

**ХАМРАХ ХҮРЭЭ**

- Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд 2 ангиллаар явуулна.
  - Анги: 1-7 дугаар анги
  - Анги: 8-12 дугаар анги

**ХУГАЦАА**

- 2025.03.13-ны өдрөөс 2025.03.28-ны өдрийн хооронд

**ТАВИГДАХ ШААРДЛАГА**

- Бүтээл нь тодорхой асуудлыг дэвшүүлсэн, бүтээлчээр хандсан байх
- Шинэ санаа дэвшүүлсэн байх
- Бүтээл ирүүлсэн он цагийн дараалаар нийтлэгдэнэ

**ДҮГНЭХ**

- Бүтээлийн хандалт, хэр олон хүнд хүрсэн эсэх (like-2 оноо, comment-1 оноо, share-1 оноо, үзэлтийн тоо)
- Бүтээлийн чанарын гүйцэтгэл, утга санааг харгалзан дүгнэнэ.

**ШАГНАЛ**

Насны ангилал тус бүрээр ялагчийг тодруулна.

1-р байр: Өргөмжлөл, 400.000₮ мөнгөн шагнал

2-р байр: Өргөмжлөл, 300.000₮ мөнгөн шагнал

3-р байр: Өргөмжлөл, 100.000₮ мөнгөн шагнал

**БҮТЭЭЛИЙГ ХҮЛЭЭН АВАХ ХАЯГ:**

- Дархан сумын Засаг даргын Тамгын газрын цахим хаяг (Дархан сум) 70371313

Хүлээж авах хаяг, утас

- Sdarkhan50@gmail.com
- 99676065

**ТӨСВИЙН ЗАДАРГАА**

| № | Зарцуулалтын төрөл | Тоо ширхэг | Нэгжийн үнэн дүн ₮ | Мөнгөн дүн ₮ |
|---|---|---|---|---|
| 1 | 1-р байрны шагнал | 2 | 400.000 | 800.000 |
| 2 | 2-р байрны шагнал | 2 | 300.000 | 600.000 |
| 3 | 3-р байрны шагнал | 2 | 100.000 | 200.000 |
| 4 | Өргөмжлөл, жааз | 6 | 30.000 | 180.000 |
| 5 | Бусад бэлтгэл ажлын зардал | | | 220.000 |
| | Нийт | | | 2.000.000₮ |

---------------------- о0о ----------------------

“УСАА ХЭМНЭЕ” ВИДЕО КОНТЕНТЫН УРАЛДААНЫ ШИЛДГҮҮД











## АРАВ. ДҮГНЭЛТ

Гангийн үйлдвэрийн хэмжээнд 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан нийт **52** ажлыг **90.231.477** төгрөгийн төсвөөр хийж гүйцэтгэсэн байна.

| Д/д | Байгаль орчныг хамгаалах арга хэмжээ | Дүн /төгрөг/ |
|---|---|---|
| 1 | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | **29.675.485** |
| 2 | Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөөний биелэлт | **5.500.000** |
| 3 | Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт | - |
| 4 | Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт | Дотоод зардал |
| 5 | Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт | **29.310.992** |
| 6 | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт | **3.945.000** |
| 7 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөөний биелэлт | **19.800.000** |
| 8 | Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах төлөвлөгөөний биелэлт | **2.000.000** |
| **НИЙТ** | | **90.231.477** |

## ХАВСРАЛТ МАТЕРИАЛУУД

1. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд хийсэн лабораторийн шинжилгээний үр дүнгүүд
2. Орон нутагтай байгуулсан хог хаягдлын гэрээ, түүний биелэлтийг нотлох баримтууд, гэрэл зургууд